

РОССИЙСКАЯ АКАДЕМИЯ НАУК  
Институт восточных рукописей  
(Азиатский Музей)



# MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXIII • 2020 • № 2

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

**Посвящается 300-летию открытия тюркской  
рунической письменности**

191186. Санкт-Петербург,  
Дворцовая наб., д. 18  
Тел.: +7 (812) 315-87-28  
<http://orientalstudies.ru>  
[mongolica@orientalstudies.ru](mailto:mongolica@orientalstudies.ru)  
[kulgan@inbox.ru](mailto:kulgan@inbox.ru)  
[dnosov@mail.ru](mailto:dnosov@mail.ru)

Регистрационный номер  
и дата принятия решения  
о регистрации в Федеральной  
службе по надзору в сфере  
связи, информационных  
технологий и массовых  
коммуникаций (Роскомнадзор):  
ПИ № ФС77-79202  
от 22 сентября 2020 г.

## Редакционная коллегия:

- И. В. Кульганек, *главный редактор,  
доктор филологических наук (Россия)*  
Д. А. Носов, *секретарь, кандидат филологических наук  
(Россия)*  
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*  
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*  
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*  
В. Капишовска, *доктор наук (Чехия)*  
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*  
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*  
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*  
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*  
Р. Поп, *доктор наук (Румыния)*  
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук,  
профессор (Россия)*  
С. Чулуун, *доктор исторических наук, профессор  
(Монголия)*  
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*  
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Выпускающие редакторы номера:

*М. А. Козинцев (ИВР РАН), И. В. Кормушин (ИЯ РАН)*

Оригинал-макет изготовлен издательством «Петербургское Востоковедение»

Литературный редактор и корректор — *Т. Г. Бугакова*

Технический редактор — *Г. В. Тихомирова*

✉ 198152, Россия, Санкт-Петербург, а/я № 2

*e-mail: pvcentre@mail.ru; web-site: http://www.pvost.org*

Подписано в печать 01.12.2020

Формат 60×90<sup>1</sup>/<sub>8</sub>. Объем 13<sup>3</sup>/<sub>4</sub> печ. л. Заказ №

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Санкт-Петербург. 4-я линия В. О., д. 5. *e-mail: editor@isvoe.ru*

ISSN 2311-5939  
DOI 10.25882/sqn6-ky22

© Институт восточных рукописей РАН  
(Азиатский Музей), 2020  
© Коллектив авторов, 2020

## В НОМЕРЕ:

Слово о Ленинградском отделении Института востоковедения АН СССР и <i>лоивановцах</i> (Т. И. Султанов) . . . . .	5
--	---

## ТЮРКОЛОГИЧЕСКИЕ ИССЛЕДОВАНИЯ

Т. К. Абдиев, К. Ш. Табалдиев. Новые находки: тюркские рунические надписи на хуме и балбале	8
Т. А. Аникеева. Вольфрам Эберхард и тюркология: о неопубликованном исследовании В. Эберхарда по тюркскому эпосу. . . . .	14
М. Е. Dubrovina. Graphemes for vowel expression in the ancient turkic runic script. . . . .	20
Д. Коç, К. Yıldırım. The Word 'Tatar' in Various Forms in Chinese Sources . . . . .	23
И. В. Кормушин. Язык орхонских и других рунических памятников как древнетюркское литературное койне смешанного уйгуро-огузского характера. . . . .	26
А. А. Туранская. "Uigurische Sprachdenkmäler" В. В. Радлова: конкорданс . . . . .	30
Ф. Г. Хисамитдинова. С. Г. Кляшторный и представления башкир о божествах и божественных силах Нижнего мира . . . . .	39
А. Ш. Юсупова. Учебные словари татарского языка XIX в. . . . .	44
Т. И. Юсупова. Научные командировки российских востоковедов в Турцию, 1920–1930-е годы: цели и результаты . . . . .	49

## МОНГОЛОВЕДЕНИЕ: ФИЛОЛОГИЯ И ИСТОРИЯ

Л. С. Дампилова, Д. Наранцэцэг. Символический язык шаманских песнопений бурят России и Монголии. . . . .	54
Ю. И. Дробышев. Образ Чингис-хана в средневековых европейских источниках . . . . .	59
А. Мөнх-Оргил. Романтизм в творчестве монгольского писателя и драматурга Л. Вангана (1920–1968) . . . . .	71
Д. А. Носов, Сэцэнбат. Сказки о Мастере-Аргачи на просторах Центральной Азии . . . . .	76
В. З. Церенов. Изображение ворона на шлеме Хонгора, героя эпоса «Джангар» . . . . .	82

## СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ

Ю. А. Боев. О переводах тайской литературы в СССР и России . . . . .	89
О. В. Лундышева. Фрагмент связанного с грешными деяниями Девадатты древнеуйгурского текста из коллекции ИВР РАН . . . . .	98

## РЕЦЕНЗИИ И НАУЧНАЯ ЖИЗНЬ

И. Арванити, Ю. В. Кузьмин. Рец. на: <i>Полянская О. Н.</i> Монголоведение в России первой половины XIX века: О. М. Ковалевский и А. В. Попов. Улан-Удэ: Изд-во Бур. ун-та, 2019. 321 с. . . . .	106
Т. Д. Скрынникова. Рец. на: <i>Байпаков К. М., Ерофеева И. В., Казизов Е. С., Ямпольская Н. В.</i> Буддийский монастырь Аблай-хит / науч. ред. Д. А. Воякин. Алматы: ТОО «Археологическая экспертиза», 2019. 400 с., ил. ISBN 978-601-7253-19-6. . . . .	107
Ж. М. Юша. Фольклорные традиции бурят Китая. Рец. на: <i>Цыбикова Б-Х. Б.</i> Фольклор шэнэханских бурят / отв. ред. Л. С. Дампилова. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2016. 312 с. . . . .	108

А. Мөнх-Оргил

## Романтизм в творчестве монгольского писателя и драматурга Л. Вангана (1920–1968)

*Ламжавын Ванганы мэндэлсний 100 жилийн ойд зориулав*

DOI 10.25882/wxky-8v08

© А. Мөнх-Оргил, 2020

В 1961 г., после долгих лет политических репрессий, Второй мировой войны и событий, связанных с развенчанием культа личности, началась массовая реабилитация политических заключенных, а в общественных кругах Монголии воцарилась атмосфера осуждения политических репрессий. Произведения репрессированных литераторов вновь стали доступны массовому читателю.

Эта атмосфера возродила в обществе веру в возможность построения новой цивилизации, светлого будущего для всех и каждого, возникла жажда созидания новой культуры. Словесное искусство не могло остаться в стороне. Литература задавала обществу тон всепроникающего оптимизма, уверенности в завтрашнем дне и стремления к лучшему. Одним из примеров этого является художественный мир, созданный Л. Ванганом.

Произведения Ламжавын Вангана стали одним из флагманов «романтизма» в монгольской литературе. Творческие эксперименты автора сыграли ключевую роль в воспитании следующего поколения драматургов и писателей. Он, безусловно, является одним из новаторов сценического и драматургического искусства Монголии XX в. Статья посвящена столетию со дня рождения художника.

**Ключевые слова:** Драматургия, монгольская литература, романтизм, Ламжавын Ванган.

**Алтангэрэлийн Мөнх-Оргил** — Ph.D, доцент, декан факультета востоковедения, Улан-Баторский государственный университет (ШХ-167, Улаанбаатар-51).  
amunkhorgil976@gmail.com

Сонгодог утгаараа биш авч, монголын шинэ уран зохиолын түүхэнд романтизмын салхи сэвэлзсэн юмдаг. Утга зохиолын түүхэнд авч ярьдаг тэр л зүй зарчим үйлчилж, уг салхийг нийгмийн нөхцөл нь, түүхэн явц нь хөөргөдөн үлээснийг мэднэ. Асуудлыг эхлээд хамгийн нүүрний эгнээнээс харсан нь дээр. Бид үнэндээ XX зууны дунд үеэс л анх удаагаа соёл иргэншлийн өөр замаар орсон. Тэгвэл энэ бүхэн уран зохиол, урлагийн салбарт, тэр дундаа тайзны амьдралд хэрхэн тусгалаа олж ирэв ээ. Товчхондоо 1960-аад оноос л шинэ нийгэм, шинэ соёл иргэншилд хөл тавьж, урьд өмнө байгаагүй ажилчин анги хэмээх цоо шинэ бүхэл бүтэн давхарга бий болж, түүнээ дагасан амьдралын хэв маяг, соёл, ёс зүй, ёс суртахууны хэм хэмжээ, үнэт зүйл бүрэлдэж эхэлсэн байна. Энгийн тусгал нь тэр үеийн төр засгийн хууль, тогтоол, заавар, шийдвэрээс эхлээд уриа тунхаг, сонины хуудас, ном зохиол, үг ярианд хүртэл тогтсон нэр томъёо, хэл хэллэг бий болсноос харагдах жишээтэй. Уран зохиолын амьдралд, түүний хууль тогтоомж, хэрэгжилт буюу зохиол бүтээл, түүний агуулга, дүр, үзэл бодол, хэл ярианд нь хүртлээ нэв-

тэрсэн нь тодорхой. Ингэж бидний мэдэх *орчин үе, шинэ хүн* гэсэн бараг онолын ухагдахуун бий болсон. Монголын зохиолчдын байгууллага, түүний их, бүгд хурал, тэндээс гарсан илгээлт, тогтоол, шийдвэр, уриалга зэрэгт энэ онол хангалттай томъёологдсон байгаа. 1960-аад оны дунд үед тэр тусмаа тайзанд хэрхэн үйлчилж байсныг ч харж болно. Монголын зохиолчдын эвлэлийн хорооны шагнал гэж одоо ч бий. Энэ шагнал Сайд нарын зөвлөлийн 1964 оны 3 сарын 18-ны өдрийн хурлын тогтоолоор батлагджээ. Шагналын зорилгыг тодорхойлохдоо “... *орчин үеийн сэдэв бүхий уран зохиолын бүх төрөл зүйл, утга зохиолын шүүмж, судлалын чанарыг сайжруулах...*” [СУЗ, 1964. №13] зорилготой хэмээн тусгайлан хэлсэн байна. 1964 оны эхнээс Д. Цэндийн “Орчин үеэ зөв дүрсэлье” зэрэг дээрх онолыг тайлбарласан, задалсан, чиглүүлсэн өгүүлэл, шүүмж хэвлэгдэх болсон. 1964 оны 3 сард Соёлын яам, МЗХ хамтран жүжгийн зохиол бичигчдийн 10 хоногийн семинар зохион байгуулж, зохих заавар зөвлөгөө, чиглэл өгч байв. Улмаар мөн оны 4 сард нь МЗХ-ноос эрхлэн жүжгийн зохиол, театрын тайзанд орчин үе,

шинэ хүнийг хэрхэн дүрсэлж буй тухай шүүмжлэгч, судлаач, найруулагч, жүжигчидтэй уулзалт хийсэн байна. Дээрээс ирсэн чиглэл явсаар хамгийн сүүлчийн шатандаа хүрч, гүйцэтгэгчиддээ очиж буй жишээ нь энэ. Энэ бүхэн бол хамгийн ил харагдаж буй, нийгмийн үзэл баримтлалын тодорхой хэрэгжилтийн шатны л зүйл.

Харин үүнийг хэрхэн тосч авсан, юу хүлээж байсан, хэрхэн ойлгосон нь бас л ялгаж салгаж харах асуудал юм шүү. Хэлмэгдэл, дайны хөл үймээнээс дөнгөж салсан, тахин шүтэх үзлийг шүүмжилсэн, улс төрийн дулаарал явагдаж байсан, 1961 оноос анх улс төрийн хэлмэгдлийг буруутган, шүүхийн шийдвэрээр улс төрийн хэрэгтнүүдийг анх удаа бөөнөөр нь цагаатгах болж, улмаар хэлмэгдсэн зохиолчдын бүтээлийг хэвлэх, судлах боломж нээгдсэн ийм л уур амьсгал нийгэмд, нийт ард иргэдийн дунд байсныг бодолцох ёстой. Энэ л сэтгэлзүйн орчин дээр шинэ иргэншил, соёл бүтээх, шинэ ирээдүй өөд дуудах, хамтаараа амьдрах, нийгэмших бас нэг үйл явц орж ирсэн хэрэг. Өөрөөр хэлбэл энгийн хүмүүсийн хувьд бол энэ бүхэн нөмөрч байсан бараан үүл сарниж, урьдын гашуун түүх мартагдаагүй юм гэхэд түр ч атугай сарниж, ирээдүйн сайн сайханд тэмүүлэх, хүсч зорих, бүтээн байгуулах, дэвжин өөдлөх сэтгэл санааны асар том орон зайг авчирсан юм. Ийм л учраас хүнд амьдрах урам зориг төрж, ирээдүйдээ итгэх итгэл улам батжиж, ямар нэг сайн сайхныг мөрөөдөж, *орчин үеийн, шинэ хүн* болох замд орсон. Хэн нэг хувь хүний өнцгөөс ингэж л харагдаж байсан юм. Уран зохиолын амьдрал, уран сайхны зохиол, зохиолын дүрүүд ийм сэтгэлзүй тээж, ийм агаараар амьсгалж, ийм л дуудлагаар сэрж, нэгдэж нийлж, хийж бүтээж байсанд гайхах явдал огт үгүй. Урам зориг, итгэл төгс, туйлын бадрангуй ийм дүрийн сэтгэл санааны агуулгыг “романтизм” гээд байгаа хэрэг. Мэдээж эндээс улс төрийн нөгөө тийш эргэсэн туйлшрал, түүний сүүдэртэй талыг ялгаж салган ойлгох хэрэгтэй. Ингэж л асар их романтик аястай дүрүүд, зохиолууд төрөн гарсан байна. Ганц нэг мөр, нэг дүр, нэг л зохиолд романтик хандлага илрэх нэг хэрэг, харин нийт уран бүтээлийн нь сэтгэл зүйн уур амьсгал болж, дүрүүдийн нь дотоод ертөнцөөс үнэртэж, хэл ярианаас нь сонсогдож, өнгө аясыг нь тодорхойлох хэмжээнд бүрэлдэнэ гэдэг бас нэг хэрэг. Ламжавын Ванганы уран бүтээл, уран сайхны ертөнц үүний өвөрмөц жишээ гэж болно. Монголын театрын тайзанд ирээдүйдээ итгэл төгс, урам зориг төгөлдөр, өөрийн гэсэн зохих үнэт зүйлтэй, түүндээ бат үнэмшилтэй, сайн сайхныг бодож, зорьж, ярьдаг, хийж бүтээдэг, үүндээ хамт олноороо хүрэх ёстой гэж итгэдэг ийм л романтик дүрүүдийг авчирч, гэрэлтэй гэгээтэй зүйлд тэмүүлж, уриалж, манлайлж байсан юм. Ерөнхий хандлагын хувьд гэсэн үг шүү дээ.

Ламжавын Ванган Зөвлөлтөд Луначарскийн нэрэмжит Театр урлагийн дээд сургуульд найруулагчийн мэргэжлээр 1951 онд төгсч ирээд жүжгийн зохиол бичих ажилд үндсэндээ орсон байдаг. 1950 хэдэн оноос дараалан гарсан “Эмч нар” (1952), “Майга

бор” (1953), “Тожоо жолооч” (1954), “Урагшлах замд” (1955), “Худалдагчийн зүүд” (1956), “Хувиа бодогч” (1956), “Салхины амт” (1958) зэрэг зохиолыг нь уран бүтээлийн хувьд жүжгийн зохиол бичих арга туршлага, эрэл хайгуул, төлөвшилтэй холбон ойлгох нь зүйтэй. Энэ нь зөвхөн өөрийн нь хувийн уран бүтээл төдийгүй, тухайн цагийн жүжгийн зохиолын ажилд зөвхөн уран сайхны туршлагаар тогтоогүй, жүжгийн зохиол, театрын онцлог, түүний онол буюу илүүтэй мэргэжлийн талаас нь зохих байдлаар нөлөөлж ирсэн байдаг. “Монголын зохиолчдын эвлэлийн хорооны тэргүүлэгчдийн өргөтгөсөн хурал дээр Л. Ванган хэлсэн үгэндээ К. С. Станиславскийн системийг бэхжүүлэн хөгжүүлэх үндсэн дээр зөвлөлтийн зохиолч, театрынхны бүтээлч хамтын ажиллагаа тодорч байгааг өөрийн орны театрын байдалтай харьцуулан яриад, “Эмч нар” жүжгээр хэрхэн бичсэнээ тодорхой өгүүлсэн юм. Л. Ванган дараа нь “Өндөр үзэл сурталтай урлагийн шинэ бүтээлийн тухай” өгүүлэл бичиж билээ” [Жамсранжав, 1972. Х. 172]. Театрын онцлог, түүний өрнийн туршлагаас эзэмшсэн, үүнийгээ шинэ үзэл санаа, агуулгатай хэрхэн уялдуулах тухай өөрийн бодолтой болсон байна. Урлах арга барилын хувьд ч өөрийн гэсэн нэг онцлогтой, “... загварчлалаас ангид биш боловч нийгмийн том үйл явдлын хүний сэтгэлд гарч буй өөрчлөлтийг бодитой, хошин шог байдлаар дүрсэлдгээрээ өвөрмөц юм” [МОУУЗТ, 1997. Х. 366]. Улмаар “Арвайхээрийн талд” (1962), “Тамирын бэр” (1963), “Жирийн хүмүүс” (1965), “Эзэд” (1966) зэрэг жүжиг нь дараалан гарсан. Эдгээр жүжиг нь нийгмийн янз бүрийн салбарыг төлөөлөх итгэл үнэмшил төгс ажилчин, түүний үйл ажил, жижиг бэрхшээл, чухам ажилчны яруу алдрыг магтан дуулах үндсэн шугам барьж байдаг. *Орчин үеийн бүтээж буй нийгэм, соёл иргэншлийн үндсэн бүтэц нь суурин иргэншил. Хэлбэр нь хамтын амьдрал, хамтын харилцаа, хамтын үүрэг хариуцлага, хамтын ёс суртахуун. Эд эс, эрэг шураг, нэгж нь шинэ хүн. Урьд өмнө байгаагүй, иргэншлийн өөр хэлбэрт байх үйлдвэр, завод, суурь машин, техник, үйлчилгээ бүхэлдээ шинэ хүний ажлын байр. “Дайны дараах үеийн жүжгийн зохиолд голлож манай утга зохиолын өнөөдрийн амин асуудал болсон хөдөлмөр ба ёс суртахуун, хөдөлмөр ба зан чанар, хөдөлмөр ба хүн, хөдөлмөр ба нийгэм гэдэг асуудлыг анхаарчээ. Бусдын хөдөлмөрийн үр дүнг завишгч хүн, мөнхүү хөдөлмөрийг гардан хийгч хүмүүсийн хоорондын зөрчил... хөдөлмөрийг цоо шинээр үзэх болсон манай нийгмийн агуулга, манай зохиолчдын үзэл санааны шинэтгэлтэй холбогдож...”* [МОУУЗТТ, 1968. Х. 403] байгаа нь шинээр бүтээж буй соёл иргэншлийн ил харагдах, басхүү шаардлагатай шинэ хүчин, түүнийг тайзанд мөн шинээр бүтээх чиг шугам болсон байна.

1965 онд бичигдсэн “Жирийн хүмүүс” жүжиг бол чухам шинэ иргэншлийн нүүр царай, түүний үзэл санааны дүрслэл, сайн сайханд тэмүүлсэн тайзны дүрслэлийн жишээ үлгэр болсон юм. Жүжигт гарч буй дүрүүд, тэдний хийж байгаа ажил, эзэмшиж буй мэргэжил, үйл хөдлөл, үг яриа бүгд тухайн үеийн

шинэ нийгмийн нүүр царай, өнгө төрх, шинээр бүрэлдэж буй соёлын хэм хэмжүүр. Архангай, Ховд, Сэлэнгэ зэрэг ХАА-н техникүмтэй аймгийн төвд энэ үйл явдал болно гэж тусгайлан хэлсэн зохиогчийн үгнээс аяндаа харагдана. Бүтээж буй нийгмийн маань нэгэн жишиг. Чадраа бол амьдралаа ч, нийгмээ ч авч яваа, авч явахуйц гол тулгуур. Түүний хоёр хүү харин хэрхэн авч явах бол, түүний нь хэрхэн зүглүүлж дэмжих вэ, эдэнд итгэж болох уу ер нь зэрэг асуултад энэ тайз хариулна. Том хүү Раднаа төгсөх ангийн оюутан боловч, байгаа байдал нь эзэмшиж буй мэргэжилдээ дургүй, харин арай өөр зүйлд тэмүүлдэг, түүнээ бас ч үгүй эргэцүүлж боддог эр. Тиймдээ ч хичээл давтаж байгаа Цэцгээд *“Би ингээж бодох юм. хэрвээ хүн бүхнийг хэн юунд авьяастай болохы нь хэлээд, мэдээд өгчихдөг бол чадвартай хүн юм уу нэг рентген аппарат шиг юм байвал мөн сайхнаа... Эрхэм минь чи наад гүжир албадлагаараа надаар нэг хөдөө аж ахуйн шилдэг мэргэжилтэн хийчихнэ гэж гүнзгий итгэсэн юм биш биз... Би олон сургууль төгсгөсөн үнэмлэх, гэрчилгээ агуулах шүүгээ, номын шилэн сав биш”* [Ванган, 1967. Х. 117] зэргээр ярьж байна. Нэг талаар амьдралын энгийн үнэн боловч, нөгөө талаар аав нь, дүү нь, хамт олон нь хөлөө олоогүй яваа иймэрхүү залуусыг засч авах учиртай. Тэгж байж хамт олноороо, нийгмээрээ урагш давших ёстой болж таарна. Тиймдээ ч Раднаа төгсөх ангиасаа сургуулиа хаяж, өөрийн шүлгийн мөр холбодог бяцхан “авьяасандаа” итгэн, түүнээ дагаж аймгийн сонины сурвалжлагч болж үзэж байх жишээтэй. Үүнд мэдээж эцэг нь, ажлын дөрөө олж яваа дүү нь, эргэн тойрон нь, ерөнхийдөө бол нийгэм цаагуураа дургүй. Нийгмийн үнэт зүйл бол хамт олон, тэдний нийтлэг эрх ашиг, бүгдээрээ хамтдаа зорьж байж хүрэх тэр ирээдүйн сайн сайхан. Ингээд энэхүү нийгмийн үнэт зүйл хувь хүний буюу Раднаагийн үнэт зүйлээс товойн гарч ирж байгаа хэрэг. Бүтэл муутай байгаа Раднаад эцгийн нь хэлж буй үгэнд энэ ялгаа, ийм үнэт зүйл, ерөөсөө энэ жүжгийн гол асуудал шингээстэй бий. *“... түр зуурын болмоор ч юм шиг хуурамч тохиолдол ч байж болох юм. Гэхдээ л нэгэн цагт угаасаа суурь муутай эхэлсэн юм чинь нураад болдоггүй юм. Амарчилсан товчилсон ер бусын эрмэлзэл үү. Амьтны доог болохоос өөр юу ч болдоггүй юм. Харин чамайг бодоход хар бор ч гэсэн дүү чинь энэ амьдралд чамаас илүү хатуу хоёр хөл дээрээ зогсоод байх шинжтэй. Жирийн хөдөлмөрчин хүмүүсийг чи үнэлж сур. Ер бусын хүмүүс гэдэг чинь тэднийг хэлж байгаа юм. Тэд чинь чам шиг жир бусын хүнийг тэжээнэ, хувцаслана, амьдруулна гээч”* [Ванган, 1967. Х. 147] Жирийн хүмүүс. Өөрөөр хэлбэл нийгэм, хамт олон. Эд бүгдийн зорилго, хүсэл тэмүүлэл, үнэт зүйл, итгэл үнэмшил бүгд нэгэн чигт байдаг. Тиймдээ ч Раднааг эзэмшсэн мэргэжлээр нь, ажлын гарааг бүр эхнээс үзүүлэхээр эцэг нь, гэр бүл нь, хамт олон нь, нийгэм нь түүнийг хөдөө авч гарч байна. Хамт олны нийгэм хэнийгээ ч хаядаггүй. Хаяхгүйгээр барахгүй байнга дэргэдээ авч явж, хайзахад нь тулж, халтирахад нь түшиж, бурууг нь ухааруулж, эцэст нь зөв замд нь оруулж байж дуусдаг.

Ийм л ирээдүйдээ итгэлтэй, бардам урам зоригтой, гуйвшгүй нэгэн үзүүрт сэтгэлийг “романтизм” гээд байгаа хэрэг. Мэдээж шууд утгаараа биш. Тэр үед бид ийм л үзэл бодолтой байсан. Бүгдээрээ ингэж л ухаарч, итгэж үнэмшиж явсан. Нийгмээрээ л шинэ соёл иргэншил, шинэ ёс суртахуун, шинэ итгэл үнэмшлээ бүтээж байгуулж байсан. Ийм л зүйлийн гараан дээр байж, хязгааргүй итгэж, түүндээ үнэнээсээ зорин тэмцэж, итгэл сэтгэлээ өгч, хөлс, хүч, цусаа ч зориулж явсан бадрангүй сэтгэлээс л романтизмыг хайгаад буй хэрэг. Ингэж романтик хувь хүний нийгмийн зорилго төгс их хүчин өөртөө нэгтгэсэнээр “романтизмд” ойртож байгаа юм.

Жирийн хүмүүсийг бичсэн тэр жил нь буюу 1965 онд “Эрхий Мажиг” хэмээх өгүүллэг нь гарсан байдаг. Ерөөс Л. Ванганы уран сайхны нэг онцлог бол зохиолын үйл явдал, агуулгын холбоо, баатрын хэл, дүрийн зан төрхийн ялгарал зэргийг хөнгөн хошин байдлаар шийдэж, егөөтэй үг хэлүүлж, шог зүйрлэлээр ёжилсноор илүү ялгарч чаддагтай холбоотой. Баатруудын нь нэр хоч, тайз дэлгэцэнд хоногшин үлдсэн яриа хэлц хангалттай батлаад өгнө. Өгүүллэгт үүсч буй асуудал, түүнээс гарах гарц, тэнд өрнөх хөнгөхөн зөрчил, баатруудын харилцан яриа, бүхэлдээ хөнгөн шог хэлбэртэй, нийгмийн сайн сайхан ирээдүй, хүсэл зорилгыг багтаасан өөдрөг тэмүүлэлтэй агуулгад зангилагддаг.

“Түмний нэг” киноны зохиол 1960 онд бичигдэж, 1962 онд ардын хувьсгалын 40 жилийн ойд зориулсан уралдаанд тэргүүн байр эзэлж, нэгдүгээр анги нь тус онд Д.Жигжидийн найруулгаар гарсан бол, 1963 онд МАХН-ын Төв хороо киноны хоёрдугаар ангийг хэлэлцээд, засвар хийх, шинэчлэх чиглэл өгч, 1965 онд “Хүний мөр” нэрээр нэлээд засагдаж дэлгэцэнд гарч байлаа. Зохиолын хоёрдугаар анги хаагдаж, тайрагдсан тухай олон яриа гарч байсан. Түүний зохиолыг Төв хороогоор оруулан, тусгайлан асуудал болгон хэлэлцсэн бөгөөд тэрхүү хурлын дэлгэрэнгүй протоколыг хожим хэвлэж нийтэд дэлгэсэн. Протоколоос, тухайн үед урлагт, уран зохиолд хандаж байсан айдас хүйдэс, хардлага сэрдлэг, өөчлөх гоочлох нийгмийн сэтгэлзүйн эмгэг, хамшинжийг харж болно. Уран бүтээлчид, зохиолчид ч үүнд дасч, хариу мэх, хөөрхөн заль бодож олсон. *“... “Түмний нэг”-ийн хоёрыг бичсэн хүн, өөрийн үзэж туулсныг бичиж. Тэгээд тэр хэргийг хийсэн хүнд үзүүлэхээр яаж батлагдах вэ дээ. Үүний учрыг ойлгов уу? Энэ бол доорд хүмүүс дээр авч бичсэн бол болох байжээ гэсэн үг. Хянадаг баталдаг хүмүүс, доод хэсэгтэй өөрсдийгөө зүйрлэдэггүй юм. Хичнээн том юмыг гаргах гэвэл төчнөөн жишжиг хэсэгт тавьдаг юм... Киног сайн хийж болно. гэхдээ нэг, хоёр газар тодорхой гэж юм хийнэ. Түүнийг нь хүн “тэр л болохгүй байна” гээд буудаад байна. Тэгж бай тавина. Хэрэв тэгэхгүй бол сайн юмыг чинь буруутгана. Мөн үү... гээд илэрхий сэргээж хөхрөв”* [Зандраабайдий, 2003. Х. 64]. Д.Намдагийн энэ үгнээс тэр үеийн уран бүтээлчдийн жаргал зовлон, тодорхой утгыг далдлах, нуух, тойруулах бяцхан заль, нийгэмдээ тааруулан сүвэгчилсэн аргыг төсөөлж болж байна.

Кино зохиолын санд үзэгдэл болсон энэ бүтээл хэдийгээр сэдвийн хувьд түүх хувьсгал, түүний явц дахь хүмүүсийн хувь заяаны өөрчлөлтийг харуулсан мэт боловч, цаг хугацааны нэлээд урт хүрээг сонгон авч, тэр нь хүний хоёр ч үеийн амьдралын асуудлыг багцлан, ингэхдээ зүгээр нэг түүхчлэлгүй гол нь нийгмийн амьдралын өргөн дэвсгэр дээр сэтгэл санааны хувирал, хөгжил, өөрчлөлтийг тухайн агшин нөхцөлд товойлгон гаргахыг зорьсон байна. Энд зохиолчийн тайз дэлгэцийн бүтээлийн уран чадварыг илтгэх зохиомжийн өвөрмөц шийдэл, дүрийн холбоос, харилцан яриа, амьдралын явцад аяндаа үүсэн гарч буй зөрчлийг харах юм. Зохиолын эхэнд гол баатар Чимид хувьсгалаас өмнө германы геологичдийн туслах ажилтнаар явж байгаад татуулсан дурсгалын зураг, зохиолын төгсгөлд баатрын хувь заяаг эргүүлэх шалтаг болон ашиглагдаж, хэлмэгдэлд оруулах түлхүүр болж байгаа нь, нэг талаас зохиомжийн шийдэл шигтгээ, нөгөөтэйгүүр зураг авахуулах болон сүүлд баримт болон гарч ирж байгаа нь тодорхой цаг үе, тухайн нөхцөлөө бүрэн дүүрэн илэрхийлж чадахуйц сонирхолтой холбоос болж өгсөн байна. Чимид, Цэрмаа хоёр хонины захад уулзаж байхад Гүрсэд ирж “... Харин чи хэтэрч байгаа байх, эх чинь ганц өдөр хэрэглээд өгье гэж гуйгаад авсан морь, чи гурав дөрөв хоног улаална гэнэ ээ гэж хэлэх завсраа Чимидийн морины эмээлийг авч хаяад хазарары нь мултлан хөөв. Морь янцгаан алсад байгаа адууны зүг давхив. Цэрмаа хонио туугаад нэг тийшээ, Гүрсэд морьтойгоо нөгөө тийшээ, Чимид эмээлээ үүрээд өөр тийшээ явцгаав” гэсэн дүрслэлээс баатруудын хувь заяа анхнаасаа өөр өөр зүгт хандаж, огт ондоо мөрөөр замнахыг бэлгэдлийн олон олон хэлээр дэглэсэн байна. Хувьсгал хэдийгээр баатруудын нийгэмд эзлэх байр суурийг сольж, байранд нь аваачиж тавьж байгаа түгээмэл шийдэл мэт харагдах ч үнэн хэрэгтээ эсрэгцэж буй гол дүрүүдийн анх байсан сэтгэл санаа, үзэл бодлын төлөвшил хувьсгалын өмнө ч дараа ч, дайны үед ч, хэлмэгдлийн цагт ч үндсэн чиг шугамаа алдалгүй, харин цагийн өөрчлөлтөд өсч, улам нээгдэж тодорч байгаа нь утга агуулгын хувьд хувьсгалын халхавч дор хувь хүний амьдрал, сэтгэлзүйг нээхэд чиглэснийг илтгэнэ. Хувьсгалаас өмнө ч, хувьсгалын дараа ч, 1932 оны эсэргүү бослогын үед ч, японы дайны үед ч, энх цагт ч өөр нэрээр нуугдаж, эсрэг байр сууринд явсан Гүрсэд зохиолын төгсгөлд толинд харж “ — өгөр толгой Гүрсэд минь чамд өдрөөс өдөрт зам чинь

хаагдаж амьдрал чинь боогдож байгааг мэдэж байна уу? Гүрсэдийн сүнс ээ! Чамаас Батсайхан асууж байна. Чи байх уу үгүй юу? Батсайхан та өгөр муу Гүрсэдийг овоо хэдэн жил аргаллаа. Даан ч аварч чадсангүй дээ”. Хэмээн ярьж байгаа нь тухайн дү-рийн хувь заяагаар дамжуулан хувьсгал, шинэ үе, сайн сайхны эсрэг үзэл бодолд чиглэсэн үзэл санаа, тайлал болж байгаа юм. Уран сайхны хувьд өвөрмөц шийдэл олсон нь нэг хүнийг толинд харуулан өөртэйгээ ч юм шиг, өөр хүнтэй ч мэтээр зөрчилдүүлэн, Гүрсэд, Батсайхан гэх нэрийн ард нуугдаж явсан нь, өөрөө өөрөөсөө зугтсан, өнгөрсөн үедээ орших гэсэн, нэг үгэндээ аль ч цагт, хаана ч, хэзээ ч оршин байх цаг хугацаа, орон зайн нөхцөлгүй болсон мөхөл, сүйрлийг суулгаж өгсөн байна. Хоёр ангит энэхүү кино зохиол монголын түүхийн тодорхой үеүдийг баатрын ганц агшны үйл байдал, яриа бодол сэтгэлээр дамжуулан, түүнд хандах хандлага ойлголтыг бас шингээж, тэрхүү далайцтай өргөн дэвсгэр орон зайд, үргэлжилж буй цаг хугацааны эргэлтэд баатрын сэтгэл санааны хөгжилт, тогтсон үзэл санааны хэв болгон дүрсэлсэн нь уран сайхны онцлог жишээ болон тэмдэглэгдэж байгаа юм.

Ламжавын Ванганы ийм гэгээлэг, ийм ахуйн гоо сайхантай, урам зоригтой, итгэл үнэмшил харин хаа очиж тийм ч аз жаргалтай амьдралаас төрж гараагүй юм. 1937 оны түүхэнд анхны 14-ийн хэрэг гэж бий. Их хэргийн анхны жишээ үлгэр болж, бусдыгаа араасаа чирэх үзүүлэн туг нь болох үйл 14 хүнд ноогдсон. Тэднээс олон хүүхэдтэй зэрэг ар гэрийн шалтгаар амьд үлдэж, шоронгийн торны цаана олон жилийг өнгөрөөж, түүнээс хойш ч үр хүүхэд нь эсэргүүний хүүхэд нэрээр ажил амьдралын бэрхийг туулахад хүргэсэн хүн нь Ванганы эцэг Ламжав байсан. Амьдралын шоглоом гэж л энэ байх. Ийм л амьдралын дараа, ийм л гуниг зовлон тээсэн сэтгэлээс, ирээдүйд итгэх их хүсэл тэмүүлэл, зөвхөн сайн сайхныг төсөөлөн мөрөөдсөн ертөнц гарсан байна. Энэ л ертөнц зохиол бүрээс нь, баатар болгоноос нь, тэдний үг яриа тутмаас нь нэвт харагддаг юм. Ламжавын Ванган өөрийн зохиолоороо монголын утга зохиолын “романтизмын” салхийг сэвэлзүүлж, туурвилзүйн томоохон туршлага үлдээж, энэ бүхнээрээ дараагийн үеийнхнийг өсгөн өндийлгөхөд гол үүрэг гүйцэтгэсний хувьд тайзны бүтээл, жүжгийн зохиолын нэгэн шинэ хуудсыг өөрийн нэртэй хамт овоглох гавьяаг хүртэх бүрэн эрхтэй.

## Ном зүй

Ванган, 1967: *Ванган Л.* “Жирийн хүмүүс”. УБ., 1967.  
*Vangan L. Zhiriin khymuus. UB., 1967.*  
*Vangan L. Ordinary people. UB., 1967.*

Жамсранжав, 1972: *Жамсранжав Г.* Зэвсэг нэгтний тухай тэмдэглэл. УБ., 1972.

*Zhamsranzhav G. Zévség nэггтнii tukhaï témдэглэл. UB., 1972.*

*Zhamsranzhav G. Notes on the Brotherhood in Arms. UB., 1972.*

Зандраабайдий, 2003: *Зандраабайдий Х.* Заяа дутсан бурхад. Монголын уран зохиолын дээжис. Боть 105. УБ., 2003.

*Zandraabaïdii Kh. Zāīaa dutsan burkhad. Mongolyn uran zokhiolyn дээжис. Bot' 105. UB., 2003.*

*Zandraabaïdiï Kh.* Unfortunate Gods. The Best of Mongolian Literature. Volume 105. UB., 2003.

СУЗ, 1964: Соёл утга зохиол. УБ., 1964.  
Soël utga zokhiol. UB., 1964.  
Culture and Literature. UB., 1964.

МОУУЗТТ, 1968: Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. УБ., 1968.

Mongolyn orchin үеийн уран зохилын товч түүх. UB., 1968.

A brief history of modern Mongolian literature. UB., 1968.

МОУУЗТ, 1997: Монголын орчин үеийн уран зохиолын түүх. (III боть). УБ., 1997.

Mongolyn orchin үеийн уран зохилын түүх. (III bot'). UB., 1997.

History of modern Mongolian literature. (In 3 volumes). UB., 1997.

### **Altangerel Munkh-Orgil** **Romanticism in the works of Mongolian playwright L. Wangan (1920–1968)**

Only in 1961, after many years of political repression, World War II and the events associated with the debunking of the personality cult, the mass rehabilitation of political prisoners began, and an atmosphere of condemnation of political repression reigned in Mongolian society. The works of the repressed authors again became available to the general public.

This atmosphere revived in society the belief in the possibility of building a new civilization, a bright future for everyone, a thirst for creating a new culture arose. Verbal art could not stand aside. Literature set the society a tone of pervasive optimism, confidence in the future and striving for the best. One example of this is the artistic world created by L. Wangan.

The works of Lamzhavin Wangan became one of the flagships of “romanticism” in Mongolian literature. The author's creative experimentation has played a key role in educating the next generation of playwrights and writers. He is undoubtedly one of the innovators of the stage and dramatic art of Mongolia in the 20th century. The article is dedicated to the 100<sup>th</sup> anniversary of the artist's birth.

**Key words:** Drama, Mongolian literature, romanticism, Lamzhavin Wangan.

**Altangerel Munkh-Orgil** — Ph.D. Associate professor, Head of the Department of oriental studies, Ulaanbaatar State University (P. O. Box-167, Ulaanbaatar-51).  
amunkhorgil976@gmail.com